



АШУУИС
Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
1942

**МОНГОЛ УЛСЫН
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

Багшийн алтан дүрэм
батлах тухай

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дүрмийн 4.1.3, 4.8.6 дахь заалт, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн хөгжлийн бодлого, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Захиргааны зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн “Багшийн алтан дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. Тушаал гарсантай холбогдуулан Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын зөвлөлийн 2014 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Багшийн алтан дүрэм” батлах тухай шийдвэрийг хүчингүйд тооцсугай.

3. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн “Багшийн алтан дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Багшийн хөгжил, цахим сургалтын газрын дарга (С.Хандмаа), холбогдох газрын дарга, салбар, бүрэлдэхүүн сургуулийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол хариуцсан дэд захирал (Г.Батбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ХҮРЭЛБААТАР

АШУУИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн
 2022 оны 02 дугаар сарын 16 -ны өдрийн
 1/15 дугаар тушаалын хавсралт



Багшийн алтан дүрэм

АШУУИС-ийн багшийг хөгжүүлэх бодлогын тулгуур баримт бичиг

Нэг. Удиртгал

АШУУИС-ийн “Багшийн алтан дүрэм” нь их сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, зорилт, үнэт зүйлсэд нийцсэн, багшийн хөгжлийг дэмжих, оролцогч талуудын үүргийг тодорхойлох, тэнхим, салбарын хүний нөөцийг төлөвлөх, залгамж халааг бэхжүүлэх, багшийн ажлын үнэлгээг боловсронгуй болгоход баримтлах бодлогын баримт бичиг юм.

Хоёр. АШУУИС-ийн багшийн баримтлах зарчим

1. Эрдмийн эрх чөлөөг дээдэлж, судалгааны ёс зүйн хэм хэмжээг баримтлан, шинжлэх ухааны хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах;
2. Суралцагчдын суралцах хүсэл тэмүүлэл, мэдлэг бүтээх сэдлийг дэмжиж, суралцагч бүрд суралцах тэгш боломжоор хангах;
3. Суралцагчийн язгуур эрх ашгийг дээдэлж, танин мэдэх эрмэлзлийг дэмжин, хүндэтгэлтэй, бодитой хандах;
4. Ардчиллын суурь зарчмыг дээдэлж, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлан, өөрийн мэдлэг, чадвараа суралцагч, нийгмийн тогтвортой хөгжлийн төлөө зориулах;
5. Аливаа асуудалд шинжлэх ухааны үндэстэй, шийдвэр гаргахдаа ил тод, нээлттэй шударга хандах;

Гурав. АШУУИС-ийн багшийн үндсэн үүрэг

АШУУИС-ийн багш багшлах, эрдэм шинжилгээ, судалгаа хийх, мэргэжлийн болон хувь ур чадвараа тасралтгүй хөгжүүлж, их сургууль, тэнхим, баг хамт олон, багш хоорондын харилцаа, үйл ажиллагааг хангах, нийгмийг соён гэгээрүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор Багшийн үндсэн найман үүргийг зарчмаа болгон дагаж мөрдөнө.

1. Мэдээлэл түгээгч, чиглүүлэгч байх
 - 1.1. Мэдээлэл дамжуулагч байх
 - 1.2. Мэдээллийг задлан шинжлэгч, мэдлэг бүтээгч байх
 - 1.3. Мэдээллийг эрэн хайхад суралцагчийг чиглүүлэгч байх
2. Туслагч, ментор байх
 - 2.1. Суралцахуйн үр дүнг тодорхойлогч байх
 - 2.2. Суралцах боломжийг нээн илрүүлэгч, идэвхжүүлэгч байх
 - 2.3. Суралцахуйг үр нөлөөтэй, үр дүнтэй болгох


3. Сургалтын хөтөлбөр хөгжүүлэгч, хэрэгжүүлэгч байх
 - 3.1. Сургалтын хөтөлбөрт хувь нэмэр оруулагч, хэрэгжүүлэгч
 - 3.2. Заахуйг төлөвлөгч, хэрэгжүүлэгч байх
 - 3.3. Хөтөлбөрийг төлөвлөгч, үнэлэгч байх
4. Үнэлгээ, дүн шинжилгээ хийгч байх
 - 4.1. Суралцагчийн үнэлгээг боловсронгуй болгох
 - 4.2. Суралцагчийг үнэлэх, суралцах үйл явцад эргэх холбоотой оролцох
 - 4.3. Суралцахуйн үр дүнг үнэлэхэд дэмжлэг үзүүлэгч байх
5. Зөв үлгэрлэгч байх
 - 5.1. Суралцагчийн үнэт зүйлс, хандлага, зан үйлд эергээр нөлөөлөгч байх
 - 5.2. Суралцагчийг хувь хүний хувьд хөгжүүлэх
 - 5.3. Суралцагчийн мэргэших сонголтод нөлөөлөгч байх
6. Зохион байгуулагч, манлайлагч байх
 - 6.1. Шийдвэр гаргах үйл явцад оролцох
 - 6.2. Сургалтын хөтөлбөрийн бүрдлийг хангах, манлайлах
 - 6.3. Өөрчлөлт шинэчлэлтэд манлайлал үзүүлэх
7. Эрдэмтэн, судлаач байх
 - 7.1. Нотолгоонд тулгуурласан үзэл баримтлалыг хөгжүүлэх, судалгаа хийх, хэвлэн нийтлэх
 - 7.2. Багшлахуйг нотолгоонд тулгуурлаж хэрэгжүүлэх
 - 7.3. Боловсролын судалгааны үр дүнг хэрэгжүүлэх, туршлагаа түгээн дэлгэрүүлэх
8. Сайн мэргэжилтэн байх
 - 8.1. Багшийн болон мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлах
 - 8.2. Хувь хүний мэдлэг, боловсролоо тасралтгүй хөгжүүлэх, иргэд, олон нийтэд боловсрол олгох
 - 8.3. Хувийн эрүүл мэнддээ хариуцлагатай хандах

Дөрөв. Багшийн хөгжлийн хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Их сургуулийн багшийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн болон хувь хүний мэдлэг, чадвар, хандлагыг тасралтгүй хөгжүүлж, туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Багшийн хөгжлийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлэх бөгөөд 3 жил тутамд шинэчилнэ.

4.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд газар, нэгжийн үүрэг:

- Багшийн хөгжил, цахим сургалтын газар нь хөтөлбөрийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, боловсронгуй болгох, газар нэгжүүдтэй хамтран ажиллах, хэрэгжилтийг зохицуулах;



- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд газар, нэгжүүдийн чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг зохицуулж, хангаж ажиллах, боловсронгуй болгох;
- Үндсэн багш нарыг чадавхжуулахад чиглэсэн үйл ажиллагааг хариуцсан газар, нэгжүүд тогтмол зохион байгуулах;

4.2 Багшийн хөгжилд бүрэлдэхүүн, салбар сургуулийн үүрэг:

- Багшийн эрдмийн эрх чөлөө, хувь хүний мэдлэг эзэмших, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах;
- Багшийн оюуны хөдөлмөр эрхлэх, ажиллах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлж, дэмжих;
- Багшийн албан тушаалын зэрэглэл, түүнд тавигдах шаардлагыг үндэслэн мэргэжил, албан тушаалын хувьд өсөн дэвших боломжоор хангах;

4.3 Багшийн хөгжилд тэнхимийн эрхлэгч, профессорын багийн үүрэг:


- Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, үйл ажиллагааг их сургуулийн болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн зорилгод нийцүүлэн чиглүүлэх;
- Салбарын хөгжил, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, багшийн мэргэжлийн болон албан тушаал зэрэглэлийн хувьд тасралтгүй хөгжих боломжийг нээлттэй, тэнцвэртэй олгох;
- Тэнхимийн хүний нөөцийн залгамж холбоог хангах, залуу багшийг дэмжиж, чадавхжуулах;
- Тэнхимийн багш нарт судалгаа хийх, хэвлэн нийтлүүлэх боломжоор хангах;
- Профессорын баг нь их сургууль, бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрхэм зорилгын хүрээнд сургалт, судалгааны ажлын нэгдлийг хангах, судалгааны ажил хийх, түгээн дэлгэрүүлэх;

Тав. Тэнхим ба профессорын баг

Тэнхим нь их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны үндсэн нэгж бөгөөд нэгдмэл зорилго, зохион байгуулалт бүхий сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаагаар салбартаа тэргүүлэгч хамт олон байна. Тэнхимийн багшийн албан тушаалын зэрэглэл нь тэнхимийн бүтцийн талст загварын жишгийг (Зураг.1) хадгалсан байх ба сургалтын ачаалалд үндэслэн тухайн хичээлийн жилд ажиллах багш нарын орон тоог тооцно.

Тэнхимийн эрхлэгч нь хамт олныг удирдан зохион байгуулах чадвартай, доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй багшийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн саналыг үндэслэн их сургуулийн захирлын тушаалаар томилно. Тэнхимийн эрхлэгчийг ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн дөрвөн жилийн хугацаагаар томилон ажиллуулах ба гүйцэтгэлийг хоёр жил тутамд үнэлнэ. Тэнхимийн эрхлэгч сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг оновчтой хуваарилах, зохицуулах, сургалтыг чанартай зохион байгуулах үүрэгтэй

ба багшийн хөгжлийг дэмжин ажиллана. Тэнхимийн эрхлэгч нь мэргэжлийн чиглэлээр тасаг, төвийг удирдана.



Зураг 1. Тэнхимийн бүтцийн талст загвар

Профессорын баг нь судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд нэгдмэл зорилготой эрдэмтэн, багш, судлаач, мэргэжилтнээс бүрдэх ба хүний нөөцийн хувьд бүрэлдэхүүн, салбар сургуулийн Эрдмийн зөвлөлийн бодлоготой уялдан ажиллана. Профессорын багийн үндсэн үүрэг нь багийн гишүүд болон суралцагчдын авьяас чадварыг хөгжүүлэх, судалгааны тэргүүлэх чиглэлээр төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, судалгааны үр дүнг олон улсын сэтгүүлд хэвлүүлэх, практикт нэвтрүүлэхэд үүрэгтэй.


Зургаа. Багшийн албан тушаалын зэрэглэл

АШУҮИС-ийн багш нь чадварлаг, ёс зүйтэй эрдэмтэн судлаач, салбартаа тэргүүлэгч мэргэжилтэн юм. АШУҮИС нь үндсэн багш, гэрээт багш, зочин багш гэсэн багшлах бүрэлдэхүүнтэй байна (Зураг.2).



Зураг 2. Багшийн ангилал ба албан тушаалын зэрэглэл

Үндсэн багш нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн албан тушаалын зэрэглэлтэй байх ба тавигдах шаардлага, хариуцлага, гэрээний нөхцөл, цалин урамшуулал ялгаатай байна (Зураг.3). Их сургуулийн үндсэн багш нь албан тушаалын зэрэглэлд тавигдах шалгуурыг хангаж ажиллах үүрэгтэй.



Зураг 3. Багш албан тушаалын зэрэглэлийн зураглал

Дадлагажигч багш нь магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй, цаашид мэргэжлээрээ өсөх, хөгжих чадвартай мэргэжилтэн, багш, судлаач байх ба төгсөлтийн өмнөх сургалтад оролцоно. Тэнхимийн эрхлэгч болон багш нарын удирдлагаар тэнхим, сургуулийн үйл ажиллагаанд оролцох үүрэгтэй.

Хүснэгт 1. Дадлагажигч багшид тавигдах шаардлага, гүйцэтгэх ажлын хүрээ

Чиглэл	Шалгуур, гүйцэтгэх ажлын хүрээ
Боловсролын зэрэг	Магистр ба түүнээс дээш зэрэгтэй
Сургалт	Төгсөлтийн өмнөх сургалтад оролцох Хичээлийн хөтөлбөр, дадлага, семинарын удирдамж хамтран боловсруулах
Эрдэм шинжилгээ	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга эзэмшсэн байх Мэргэжлийн чиглэлээр дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх
Мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагаа	Мэргэшүүлэх сургалтад хамрагдах Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх Мэргэжлийн нийгэмлэг холбооны гишүүн байх
Оюутны хөгжил	Оюутанд зөвлөгөө өгч, удирдан чиглүүлэх
Багшийн хөгжил	Анагаах ухааны боловсрол судлалын 4-өөс дээш багц цагийн сургалтад хамрагдсан байх Мэргэжлийн мэдлэг, ур чадвараа хөгжүүлж 2-оос дээш багц цагийн сургалтад хамрагдсан байх

Багш нь АШУУИС-д 3-аас доошгүй жил багшилсан, мэргэжил, эрдэм шинжилгээ, сургалтын хувьд хөгжих боломж, чадвартай багш байх ба эмнэлзүйн тэнхимийн багш үндсэн эсвэл төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байна. Багш нь

төгсөлтийн өмнөх сургалтад оролцох бөгөөд эрдэм шинжилгээ, судалгааны ажил заавал гүйцэтгэнэ. АШУҮИС-ийн багш нь 10 жилийн дотор докторын зэргийг хамгаалах үүрэгтэй.

Хүснэгт 2. Багшид тавигдах шаардлага, гүйцэтгэх ажлын хүрээ

Чиглэл	Шалгуур, гүйцэтгэх ажлын хүрээ
Багшилсан туршлага	АШУҮИС-д 3-аас дээш жил багшилсан байх
Боловсролын болон мэргэжлийн зэрэг	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй Мэргэжлийн зэрэгтэй
Сургалт	Төгсөлтийн өмнөх сургалтад оролцох Сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд үнэлгээ хийх
Эрдэм шинжилгээ	Эрдэм шинжилгээ, судалгааны арга эзэмшсэн, бие даан судалгаа шинжилгээ хийх чадвартай байх Мэргэжлийн чиглэлээр дотоод, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх
Мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагаа	Мэргэшүүлэх сургалтад хамрагдах Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх Мэргэжлийн нийгэмлэг холбооны гишүүн байх
Оюутны хөгжил	Оюутанд зөвлөгөө өгөх, удирдан чиглүүлэх
Багшийн хөгжил	Ажиллах хугацаандаа АШУҮИС болон ижил зэрэглэлийн бусад байгууллагаас зохион байгуулсан багшийн хөгжлийн 9-өөс дээш багц цагийн сургалтад хамрагдсан байх

Ахлах багш нь судалгаа, шинжилгээний ажлыг бие даан удирдах чадвартай, эрдэм шинжилгээний бүтээлтэй, доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй мэргэжилтэн, судлаач байна. Ахлах багш төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтыг удирдан явуулах ба судалгааны төсөлт ажил удирдах чадвартай байна. Эмнэлзүйн тэнхимийн багш мэргэжлийн ахлах ба түүнээс дээш зэрэгтэй байна.

Хүснэгт 3. Ахлах багшид тавигдах шаардлага, гүйцэтгэх ажлын хүрээ

Чиглэл	Шалгуур, гүйцэтгэх ажлын хүрээ
Багшилсан туршлага	АШУҮИС-д 8-аас дээш жил багшилсан байх
Эрдмийн болон мэргэжлийн зэрэг	Докторын зэрэгтэй Мэргэжлийн ахлах эсвэл тэргүүлэх зэрэгтэй
Сургалт	Төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтад оролцох Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх, сургалтын төлөвлөгөө боловсруулахад оролцох
Эрдэм шинжилгээ	Эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажил удирдах Web of Science, Scopus, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй хөндлөнгийн хянан магадалгаа бүхий сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх
Мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагаа	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх Эмнэлгийн мэргэжилтэн, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаанд оролцох Мэргэжлийн нийгэмлэг холбоонд гишүүн байх
Оюутны хөгжил	Суралцагчид зөвлөгөө өгөх Төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн сургалтад оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажил удирдах, зөвлөх
Багшийн хөгжил	Ажиллах хугацаандаа АШУҮИС болон ижил зэрэглэлийн бусад байгууллагаас зохион байгуулсан Анагаах ухааны боловсрол судлалын сургалтад хамрагдах буюу зохион байгуулж нийт 12 багц цагийн сургалтад хамрагдсан байх

5845459

Дэд профессор нь салбартаа манлайлагч, доктор ба дэд профессороос дээш эрдмийн зэрэг, цолтой судлаач багш байна. Дэд профессор нь төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтыг удирдан явуулах, эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлын удирдан манлайлж ажиллана.

Хүснэгт 4. Дэд профессорын албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлага, гүйцэтгэх ажлын хүрээ

Чиглэл	Шалгуур, гүйцэтгэх ажлын хүрээ
Ажлын туршлага	АШУҮИС-д 10-аас дээш жил багшилсан байх
Эрдмийн болон мэргэжлийн зэрэг	Докторын зэрэгтэй АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлөөс олгосон дэд профессор эсвэл профессор цолтой байх Мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй
Сургалт	Төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтад оролцох Хичээлийн хөтөлбөр боловсруулах, хичээлийн хөтөлбөрт үнэлгээ хийх, боловсронгуй болгох багийг ахлан ажиллах
Эрдэм шинжилгээ	Эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажил удирдах Web of Science, Scopus, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй хөндлөнгийн хянан магадалгаа бүхий сэтгүүлд нэгдүгээр зохиогчоор, эсвэл хариуцлагатай зохиогчоор өгүүлэл хэвлүүлэх
Мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагаа	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх Судалгааны төслийн баг, профессорын багийг удирдах Эмнэлгийн мэргэжилтэн, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаанд оролцох
Оюутны хөгжил	Төгсөлтийн сургалтад суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил удирдах, зөвлөх Суралцагчид зөвлөгөө өгөх
Багшийн хөгжил	АШУҮИС болон ижил зэрэглэлийн бусад байгууллагаас зохион байгуулсан боловсрол судлалын сургалтад хамрагдах болон зохион байгуулах байдлаар 16 багц цаг цуглуулсан байх

Профессор нь мэргэжлийн салбартаа тэргүүлэгч, профессор цолтой эрдэмтэн судлаач багш байна. Профессор нь төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтыг удирдан явуулах, залгамж халааг бэлтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажлыг удирдан манлайлж ажиллана.

Хүснэгт 5. Профессорын албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлага, гүйцэтгэх ажлын хүрээ

Чиглэл	Шалгуур, гүйцэтгэх ажлын хүрээ
Ажлын туршлага	АШУҮИС-д 15-аас дээш жил багшилсан байх
Эрдмийн болон мэргэжлийн зэрэг	Доктор зэрэгтэй АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлөөс олгосон профессор цолтой Мэргэжлийн зөвлөх зэрэгтэй
Сургалт	Төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтад оролцох Хичээлийн хөтөлбөр боловсруулах, хичээлийн хөтөлбөрт үнэлгээ хийх, боловсронгуй болгох багийг ахлан ажиллах
Эрдэм шинжилгээ	Эрдэм шинжилгээ, судалгааны төсөлт ажил удирдах Web of Science, Scopus, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй хөндлөнгийн хянан магадалгаа бүхий сэтгүүлд хариуцлагатай зохиогчоор өгүүлэл хэвлүүлэх
Мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагаа	Профессорын багийг удирдах Эмнэлгийн мэргэжилтэн, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаанд оролцох Зөвлөх эмч, төслийн зөвлөх, тасаг нэгжүүдэд зөвлөхөөр ажиллах

Оюутны хөгжил	Суралцагчид зөвлөгөө өгөх, удирдан чиглүүлэх Төгсөлтийн сургалтад суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил удирдах, зөвлөх
Багшийн хөгжил	Ажиллах хугацаандаа АШУҮИС болон ижил зэрэглэлийн бусад байгууллагаас зохион байгуулсан Анагаах ухааны боловсрол судлалын сургалтад хамрагдах болон зохион байгуулах байдлаар 22 багц цаг цуглуулсан байх

Профессор, дэд профессорын албан тушаалын зэрэглэлийн нэг орон тоонд болзол хангасан хэд хэдэн нэр дэвшигч байх тохиолдолд сүүлийн 5 жилийн Web of Science, Scopus, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо, түүнд зохиогчийн оруулсан хувь нэмэр, удирдаж хэрэгжүүлсэн төсөл, багшийн ажлын үнэлгээний дүнд үндэслэн тухайн албан тушаалын зэрэглэлд ажиллуулна. Профессор, дэд профессор, ахлах багшийн орон тоонд болзол хангасан багш нэр дэвшигч байхгүй тохиолдолд шаардлагыг бууруулж орон тоог нөхөж ажиллуулахыг хориглоно.

Гэрээт багш нь сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн туршлагатай, салбартаа манлайлагч судлаач, багш, мэргэжилтэн байх ба нэг жил хүртэлх хугацаагаар гэрээ байгуулан ажиллана. АШУҮИС-д мөрдөж буй ёс зүйн болон сургалттай холбоотой дүрэм, журмыг мөрдөж ажиллана.

Зочин багш нь эрдэм шинжилгээ, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаагаар салбартаа манлайлагч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, АШУҮИС-д уригдан ажиллаж буй эрдэмтэн, судлаач, багш, эмч, мэргэжилтэн юм. Зочин багштай нэг жилийн хугацаатай гэрээ байгуулах бөгөөд АШУҮИС-д мөрдөгдөж буй ёс зүйн болон сургалттай холбоотой бүх дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй. Зочин багшийн тодорхойлолт, хэвлэлийн бүтээл, намтар, анкет, үнэмлэх, нэрийн хуудсанд “Зочин” гэдэг тодотголыг албан тушаалын зэрэглэлийн өмнө заавал бичнэ.

АШУҮИС-ийн багшийн албан тушаалын зэрэглэлээс хамааран төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтын ачаалал, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэлд харилцан адилгүй шаардлага тавина. Багшийн мэргэжил, албан тушаалын зэрэглэл тасралтгүй өсөн хөгжих нөхцөлийг хангах ба албан тушаалын зэрэглэл өөрчлөхөд шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл, багшийн ажлын үнэлгээний дүнг үндэслэл болгоно. Багшийн ажлын тайланг тэнхимийн хурлаар хэлэлцэж, албан тушаал зэрэглэл өөрчлөх саналыг хариуцсан нэгжид хүргүүлж, их сургуулийн захирлын тушаалаар батална (Хүснэгт.6).

Хүснэгт 6. Багшийн албан тушаалын зэрэглэл батлах үйл явц

№	Хугацаа	Нэгж	Үйл ажиллагаа
1	V сар	Багш	Ажлын тайлан
2	V-VI сар	Тэнхимийн хурал	Багш тус бүрийн тайланг хэлэлцэж тэнхимийн багш бүрийн албан тушаалын зэрэглэлийг тодорхойлж, нэр дэвшүүлсэн хурлын тэмдэглэл Шинэ багш авах хэрэгцээг хэлэлцсэн хурлын тэмдэглэл
3	VI-VIII	Багшийн хөгжил, цахим	Багшийн ажлын үнэлгээ

	сар	сургалтын газар	Тэнхимийн багш нарын албан тушаалын зэрэглэлд өөрчлөлт оруулах санал Сонгон шалгаруулалт
4	VIII-IX сар	Багшийн хөгжил, цахим сургалтын газар, Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулах газар, Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулах газар, Захиргаа, хүний нөөцийн газар	Багш нарын албан тушаалын зэрэглэлийн өөрчлөлт Захирлын тушаалаар батлах Шинээр ажилд орж буй багш нарын нэрсийг Захирлын тушаалаар батлах

Долоо. Багшийн ажлын хавтас болон багшийн ажлын дэвтэр

Үндсэн багш нь багшийн ажлын хавтас, хичээлийн файлын санг холбогдох цахим системд байршуулж, тасралтгүй шинэчлэн сайжруулж ажиллана. Багшийн ажлын хавтас дараах бүрдэлтэй. Үүнд:

Ерөнхий хэсэг:

- Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт
- Боловсролын болон эрдмийн зэргийн диплом, мэргэшлийн үнэмлэх, багшлах эрхийн гэрчилгээ, шагнал урамшуулал
- Ажлын төлөвлөгөө, тайлан
- Хувь хүний хөгжлийн төлөвлөгөө

Сургалт (сүүлийн 3 жилээр):

- Цагийн гүйцэтгэл
- Сургалтын технологийн шинэчлэл, аргууд
- Сургалтад хийсэн хөндлөнгийн болон өөрийн үнэлгээ
- Хичээлийн үнэлгээ, суралцагчийн сурлагын амжилт, чанар
- Сурах бичиг, гарын авлага, удирдамж

Эрдэм шинжилгээ:

- Эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл, илтгэл
- Оюуны өмчийн гэрчилгээ, патент

Мэргэжлийн болон нийгмийн үйл ажиллагаа:

- Эмнэлзүйд нэвтрүүлсэн оношилгоо, эмчилгээний шинэ технологи
- АШУҮИС-ийн харьяа эмнэлэг, сувилалд гүйцэтгэсэн ачаалал, түшиц эмнэлэгтэй байгуулсан гэрээ
- Мэргэжлийн нийгэмлэг, холбооны гишүүний үнэмлэх
- Их сургуулийн нэрийн өмнөөс хийж гүйцэтгэсэн ажлууд
- Урлаг, спорт, нийгмийн үйл ажиллагаанд оролцсон байдал

Багшийн хичээлийн файлын сан хичээлийн хөтөлбөр, хөтөч, удирдамж, хичээлийн үзүүлэн, таниулах материал, сорил, тохиолдлын сан зэргээс бүрдэнэ. Үндсэн багш нь багшийн ажлын дэвтэртэй байх ба суралцагчдын ирц, дүн, үнэлгээ, суралцагчдад өгсөн зөвлөгөө, хичээлийн сэдвийн тэмдэглэл зэргийг бүрэн хөтөлж, зааврын дагуу ашиглана.

